

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/01/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 90900910

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478

Цахим хаяг:

Аудитор:

Г.Намчинсүрэн

Утас: 91995689

Цахим хаяг: Namchinsuren999@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.13. Шилэн дансны мэдээлэл	12
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	12
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
Менежментийн захидал	14
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	17
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	25
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	26
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ЭНХ-АМГАЛАН ТАНАА
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580	
2020.03.24 № 125	
танай _____	-ны № _____ Т _____
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
006020172	

Үүрэг, хариуцлага

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Д.АНХБАЯР

2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ц.Энх-Амгалан танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 16-наас 2020 оны 03 дугаар сарын 25 –ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 03 сарын 02-ны өдрийн 1-1/82 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь даатгуулагчдынхаа итгэл найдвар, мэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхэд оршино.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих,
- Даатгуулагч, ажил олгогчдыг бүртгэж даатгалд хамруулах, шимтгэл хураамжийн орлогыг хурааж нийгмийн даатгалын санг бүрдүүлэх,
- Иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоон олгох

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах
Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн Даатгалын багц хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Бусад холбогдох хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НДЕГ-ийн дэргэдэх МТТөвийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хийсэн Нийгмийн даатгалын сангийн цогц программ хангамж ашигладаг байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 20 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их, дунд, бага/” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 39445993.2 мянган төгрөгөөс тооцон 788919.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувь буюу 887117.1 мянган төгрөгөөр тооцсон нь байгууллагын нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг байдлын түвшин хэт бага гарч байгаа тул нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 715552.4 мянган төгрөгөөр буюу 42.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,069,469.6	1,726,175.3	656,706.7
Авлага	301,571.8	405,572.0	104,000.2
Урьдчилгаа			
Бараа материал	14,479.6	17,384.4	2,904.8
Үндсэн хөрөнгө	305,760.7	257,701.3	-48,059.4
Нийт хөрөнгө	1,691,280.6	2,406,833.0	715,552.4
Өр төлбөр	86,082.6	88,386.5	2,303.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,605,198	2,316,446.5	713,248.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,691,280.6	2,406,833.0	715,552.4

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 95,5 сая, бусад авлага 6,9 сая төгрөг, акт төлбөрийн авлага 1,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 5-аас дээш жил хугацаа хэтрэлттэй 225,7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, 2-3 жилийн хугацаа хэтрэлттэй 20713,1 мянган төгрөгийн НДШ-ийн, 604,2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Үүнээс барагдах боломжгүй, эрсдэлтэй 22567 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь үйл ажиллагааны тайланд НДС-аас авах авлагаар тусгасан боловч НДС-д нийгмийн даатгалын үйл ажиллагаанд өгөх өглөг бүртгэлд байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь НДЕГ-аас шууд олгодог маягтыг оны сүүлээр дараа жилийн хэрэгцээгээр бөөнөөр авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд олон жилийн өмнө худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Бараа материалын дансанд хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн, захиалагч байгууллагад шилжүүлээгүй бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Тайлант хугацааны элэгдлийн зардлыг хассанаас шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгөөс үнэ төлбөргүй шилжүүлээгүй, актлаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тэтгэмжийн өглөг 71,6 мянган төгрөгөөр өссөн, бусад өглөг 5823,9 мянган төгрөгөөр өссөн, СДД-ийн илүү төлөлт 7480,7 мянган төгрөгөөр өссөн, НДШ-ийн илүү төлөлт 1786,5 мянган төгрөгөөр буурсан, ЭМД-ийн өглөг 52,0 мянган төгрөгөөр буурсан ажилсан жил нөхөн даатгалын өглөг 9,090,6 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтүүдийн зөрүүгээр 2303,9 мянган төгрөгийн өсөлттэй гарчээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй

Өр төлбөр дансны үлдэгдэлд барьцаа хөрөнгө байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2134.06 сая төгрөг болж 713.2 сая төгрөгөөр өссөн нь .тайлант хугацааны хуримтлагдсан ашиг 681.36 сая төгрөг, НББ-ын бодлогын өөрчлөлтийн 31.8 сая төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга нь 31886.3 мянган төгрөгийн бичилт нь өнгөрсөн хугацаанд илүү олгосон тэтгэвэр тэтгэмжийг буцаан авах 35059.4 мянган төгрөг өсгөсөн, дутууг нөхөж олгох 3173.1 сая төгрөгөөр бууруулсан хуримтлагдсан үр дүнгийн дансанд бичилт хийсэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Нийгмийн даатгалын хэлтэс нь тайлант онд 10,529,257.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 12,765,176.98 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 121.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого
төгрөг/

/мянган

д/д	Нийгмийн даатгалын сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэвэр	8,706,304.50	10,356,250.34	1,649,945.84	119.00 %
2	Тэтгэмж	931,796.50	1,160,661.41	228,864.91	124.60 %
3	ҮОШМӨ	718,087.30	939,245.99	221,158.69	130.80 %
4	Ажилгүйдэл	173,069.40	309,019.24	135,949.84	178.60 %
	Нийт дүн	10,529,257.70	12,765,176.98	2,235,919.28	121.20 %

Орлогын төлөвлөгөө 2,235,919.28 мянган төгрөгөөр давсан нь аж ахуйн нэгж байгууллагуудын НДШ, сайн дурын даатгуулагчдыг олноор хамруулан шимтгэл төлүүлж ажилласнаас шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх НД-ын сангийн зарцуулалт, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зориулан 41,334,487.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 41,334,487.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын эх үүсвэрийг Нийгмийн даатгалын сангаас бүрэн санхүүжүүлдэг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын төлөвлөлтийн 41,334,487.6 мянган төгрөгөөр баталсан. НД-ын шимтгэлээр 13,148,780.18 мянган төгрөг, НДЕГ, НД-ын төвлөрсөн сангаас 28,185,707.42 мянга төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

Урсгал зардлыг 41,334,487.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 40,941,689.46 мянган төгрөг буюу 99,05 хувийн гүйцэтгэлтэй 392,798.1 мянган төгрөгийн хэмнэлттэй гарсан байна. Үүнээс нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн зардал 387,535.4 мянган төгрөгийн хэмнэлттэй, үйл ажиллагааны зардал 5626,7 мянган төгрөгийн хэмнэлттэй байна

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хөрөнгө төсөвлөгдөөгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 40,941,689.46 мянган төгрөг буюу 99.05 хувьтай байгаа нь НД-ын тэтгэвэр, тэтгэмжийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 7959.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс албан томилолтын зардалд 839.9, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 6000.0, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 1120.0 нийт 7959.6 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 20 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 23 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 489396.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0.00 мянган төгрөгийн алдааг залруулж, 8357.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 474197.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6841.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 489396.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 482555.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн дагуу ажилдаа буцан орсон 5 албан хаагчийн ажилгүй байх хугацааны нийт 35435.0 мянган төгрөгийн цалинг байгууллагаас нөхөн төлж хохирлыг барагдуулсан нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1 дэх заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Захиргааны ерөнхий хуулийн 103.3 дах заалтын дагуу байгууллагын хохирлыг барагдуулах албан шаардлагыг дээд шатны байгууллагын дотоод аудитын албанд хүргүүлэх.

2. Тайлант онд барилгын дулааны узель хийх ажлыг "Их-Азар" ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч тухайн гэрээнд уг ажлыг гүйцэтгэх байршил тодорхойгүй, гэрээний нийт үнийн дүн 4000000 төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч тухайн ажлыг гүйцэтгэх техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв байхгүй, одоог хүртэл тухайн ажил хийгдээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ хүртэл биелүүлээгүй, гэрээнд заасны дагуу хариуцлага

тооцоогүй нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тогтоолын 5.2 дахь заалттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

3. Шатахууны зардлыг тооцон олгохдоо холбогдох автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 327.5 мянган төгрөгийг олгож Дэд бүтцийн сайдын 2004 оны 109 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

4. Аж ахуй материалаас 120.0 төгрөгийн зардлыг шууд зардалд бичиж зарцуулсан нь УСНББОУС-12 дагуу хөрөнгийн шинж чанартай бараа материалыг үнэлж, бүртгэлд тусган, бараа материалын орлого, зарлагыг данс бүртгэлд үнэн зөвөөр тайлагнах гэсэн заалттай бүрэн нийцээгүй, үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

5. Шуудан холбооны зардлаас Төсвийн шууд захирагчийн 2019 оны 132 дугаар сарын 23-нд А/46 тоот тушаалаар НДШ-ийн авлага бууруулах,

хариуцсан байгууллага нийгмийн даатгалын хамрагдлыг нэмэгдүүлэх, шинээр ажил олгогчийг нэмэгдүүлэн бүртгэх ажлыг эрчимжүүлэн сайжруулах ажлын зардалд ажилчдын холбооны зардал 2000.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч тухайн холбооны зардлыг ажилчдад олгосон анхан шатны баримтгүй, хийх ажлын төлөвлөгөө тайлан байхгүй байгаа нь ННБ-ийн тухай хуулийн 13.1, 20.1.4, 20.2.4 , санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

6. Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 4 иргэний 939.0 мянган төгрөгийг илүү, 2 хүний 971.6 мянган төгрөгийг дутуу тооцон олгосон нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 22 дугаар тогтоолын 4.1, 5.6 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

7. Тайлант оны эцэст 405572.0 мянган төгрөгийн авлага, 88386.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлээс 9 байгууллага буюу 55195.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгаажуулж бусад 350376.3 мянган төгрөгийн авлага, 88386.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь ННБ-ийн тухай 5 дугаар зүйл, 20.2.6,20.2.7 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 6841.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 676.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос 676.8 мянган төгрөгийг барагдуулсан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээгүй байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сүл талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тэтгэврээ тогтоолгон 36 сарын тэтгэмжээ авч ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийг түр албан тушаалд НД-ын байцаагчаар томилон цалинг тогтоохдоо ТЗ-6-5 шатлалын 731631 төгрөгөөр тооцон, зэрэг дэвийн нэмэгдлийн 20 хувиар, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 25 хувиар тооцож нийт 2703.9 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.1, Төрийн албаны тухай хуулийн 46.2.2 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх, батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.1, Төрийн албаны тухай хуулийн 46.2.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ахмадын санд шаардагдах хөрөнгийг тухайн жил батлуулалгүйгээр нийт 2365.9 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 2017 оны 197 тогтоолын 2 дугаар хавсралтын 1.3 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх, батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2017 оны 197 тогтоолын 2 дугаар хавсралтын 1.3 дахь заалт

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шатахууны зардлаас анхан шатны баримтын бүрдэл дутуу 915.8 мянган төгрөгийг зарцуулсан нь ННБ-ийн тухай хуулийн 13.7, 20.1.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж:

ННБ-ийн тухай хуулийн 13.7, 20.1.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

4. Зардал данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

ЗГ-ын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг зөрчин албан ажлын хэрэгцээний авто машин хэрэглэх эрхгүй албан тушаалтан хот дотор автомашин хэрэглэн 726.9 мянган төгрөгийг үргүй зарцуулсан байна.

4.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх

4.3. Өгсөн зөвлөмж:

ЗГ-ын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

5. Зардал данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Нярвын тайлан дахь аж ахуй материалын дүн бараа материалын тодруулга тайлангийн дүнгээс 129.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь НББ-ийн 20.2.3-дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

5.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох дүрэм журам зөрчигдөх

5.3. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн 20.2.3-дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

6. Зардал данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 3 хүний ажлаас халагдсан тушаал шийдвэр ирээгүйгээс илүү, дутуу олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 22 дугаар тогтоолын 5.6 дахь заалтыг зөрчсөн байна.

6.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх

6.3. Өгсөн зөвлөмж:

Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 3 хүний ажлаас халагдсан тушаал шийдвэрийн ажил олгогчоос гаргуулж илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг санд төвлөрүүлж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 22 дугаар тогтоолын 6.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн. зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,385,519,899.21	2,149,131,648.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
		1,069,468,566.21	1,726,175,299.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,069,468,566.21	1,726,175,299.23
3121	Төгрөг	1,069,468,566.21	1,726,175,299.23
31212	Монгол банкин дахь харилцах		7,303,815.39
31213	Арилжааны банк дахь харилцах	1,069,468,566.21	1,718,871,483.84
33	АВЛАГА	301,571,774.31	405,572,003.05
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	274,818,844.82	371,983,664.17
335	Бусад авлага	26,752,929.49	33,588,338.88
3351	Байгууллагаас авах авлага	26,652,929.49	33,588,338.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	100,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	14,479,558.69	17,384,346.66
354	Хангамжийн материал	14,479,558.69	17,384,346.66
35410	Бичиг хэргийн материал	406,000.00	8,000.00
35420	Аж ахуйн материал	9,478,695.00	9,333,496.00
35470	Бусад хангамжийн материал	4,594,863.69	8,042,850.66
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	305,760,705.76	257,701,344.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	305,760,705.76	257,701,344.25
392	Биет хөрөнгө		

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		298,790,705.76	250,731,344.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	188,391,995.12	188,391,995.12
39202	Хуримтлагдсан элэгдэл		8,156,698.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,980,000.00	89,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	70,060,555.45	85,057,222.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	107,186,248.00	107,186,248.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	58,608,008.57	76,754,750.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,524,100.00	76,524,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	34,623,073.34	41,382,328.34
393	Биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
39301	Програм хангамж	3,666,123.00	3,666,123.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,666,123.00	3,666,123.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,691,280,604.97</u>	<u>2,406,832,993.19</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>86,082,640.25</u>	<u>88,386,514.68</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,082,640.25	88,386,514.68
413	Өглөг	14,163,573.05	19,915,937.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	14,880.60	14,890.60
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,446,255.98	19,198,610.10
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	577,800.00	577,800.00
4136	Бусад өглөг	124,636.47	124,636.47
41361	Байгууллагад төлөх өглөг	124,636.47	124,636.47
414	Урьдчилж орсон орлого	71,919,067.20	68,470,577.51
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	71,919,067.20	68,470,577.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,605,197,964.72</u>	<u>2,318,446,478.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,605,197,964.72	2,318,446,478.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,679,914.75	181,679,914.75
51101	Өмч: - төрийн	181,679,914.75	181,679,914.75
512	Хуримтлагдсан үр дүн	1,420,811,869.30	2,134,060,383.09

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	882,220,119.38	1,452,698,197.57
51220	Тайлант үеийн үр дүн	538,591,749.92	681,362,185.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,706,180.67	2,706,180.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,691,280,604.97</u>	<u>2,406,832,993.19</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	70,820,591,677.18	45,037,219,999.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,865,591,937.18	15,904,267,172.45
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	12,865,591,937.18	15,904,267,172.45
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,726,864,075.16	11,094,762,890.54
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	956,464,620.64	1,148,144,066.27
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	612,015,085.73	714,098,097.93
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	181,949,944.68	212,269,302.27
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	2,388,298,210.97	2,734,992,815.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,342,369.83	87,477,366.95
120	Нийтлэг татварын бус орлого	78,342,369.83	87,477,366.95
120002	Хүүгийн орлого	20,416,347.13	52,548,642.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,966,294.57	31,501,552.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,823,611.28	30,659,252.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,907,285.67	842,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,235,397.62	
120009	Бусад орлого	12,959,728.13	3,427,171.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,876,657,370.17	29,045,475,460.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,361,820.00	7,959,960.00

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,361,820.00	7,959,960.00
1330	Төсвийн захирагчдаас	57,401,812,950.17	28,439,963,800.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,401,812,950.17	28,439,963,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	466,482,600.00	597,551,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	466,482,600.00	597,551,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	70,141,525,568.86	44,355,857,813.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,141,525,568.86	44,355,857,813.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	503,868,066.51	611,567,990.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,581,316.00	411,467,441.00
210101	Үндсэн цалин	253,451,370.00	337,702,682.00
210102	Нэмэгдэл	56,319,732.00	65,352,759.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,390,000.00	8,412,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,420,214.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,327,752.00	48,132,922.54
210201	Тэтгэврийн даатгал	26,325,997.18	32,220,178.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,252,405.09	3,980,592.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,599,564.41	3,181,586.18
210204	Ажилгүйдлийн даатгал	648,907.91	794,193.22
210205	Эрүүл мэндийн даатгал	6,500,877.41	7,956,372.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,239,923.00	29,525,800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,358,612.00	3,258,000.00
210302	Түлш, халаалт	22,895,319.00	23,047,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,985,992.00	2,720,000.00
210304	Байрны түрээс		500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,544,583.48	19,393,549.00
210401	Бичиг хэрэг	3,386,500.00	4,778,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,958,100.00	6,651,500.00

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,705,976.18	4,956,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,494,007.30	3,007,249.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,409,200.00	6,429,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,980,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	429,200.00	4,429,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,649,200.00	5,825,560.00
210702	Дотоод албан томилолт	3,649,200.00	5,825,560.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,402,987.20	33,634,156.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,290,541.00	19,335,223.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	1,428,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	399,825.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	41,250.00	50,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,926,160.00	5,117,170.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,639,211.20	7,183,763.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,713,104.83	57,159,361.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400,000.00	9,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,313,104.83	48,059,361.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,637,657,502.35	43,744,289,823.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,859,692,997.62	40,381,207,909.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,827,612,797.62	40,329,409,409.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,080,200.00	9,120,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		42,678,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,777,964,504.73	3,363,081,914.59
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,777,964,504.73	3,363,081,914.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	679,066,108.32	681,362,185.52

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	140,474,358.40	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,191,026.62	
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	137,283,331.78	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(140,474,358.40)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	538,591,749.92	681,362,185.52

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	70,724,446,255.96	44,979,676,628.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,764,885,456.58	15,815,791,893.43
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	12,764,885,456.58	15,815,791,893.43
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,650,349,928.67	11,036,404,115.03
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	948,876,777.78	1,140,264,347.64
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	607,398,909.31	710,890,949.78
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	181,966,299.66	210,413,737.65
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	2,376,293,541.16	2,717,818,743.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,654,729.21	129,373,074.67
120	Нийтлэг татварын бус орлого	94,654,729.21	129,373,074.67
120002	Хүүгийн орлого	20,416,347.13	52,548,642.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,238,382.08	74,458,460.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,331,096.41	73,616,160.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,907,285.67	842,300.00
120009	Бусад орлого		2,365,971.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,864,906,070.17	29,034,511,660.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,361,820.00	7,959,960.00

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,361,820.00	7,959,960.00
1330	Төсвийн захирагчдаас	57,390,061,650.17	28,429,000,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,390,061,650.17	28,429,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	466,482,600.00	597,551,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	466,482,600.00	597,551,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>70,076,313,777.48</u>	<u>44,322,969,895.08</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,076,313,777.48	44,322,969,895.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,557,977.11	556,000,506.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,581,316.60	411,467,431.00
210101	Үндсэн цалин	253,451,371.00	337,702,682.00
210102	Нэмэгдэл	56,319,731.60	65,352,749.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,390,000.00	8,412,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,420,214.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,327,752.00	48,132,922.54
210201	Тэтгэврийн даатгал	26,325,997.18	32,220,178.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,252,405.09	3,980,592.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,599,564.41	3,181,586.18
210204	Ажилгүйдлийн даатгал	648,907.91	794,193.22
210205	Эрүүл мэндийн даатгал	6,500,877.41	7,956,372.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,239,923.00	29,525,800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,358,612.00	3,258,000.00
210302	Түлш, халаалт	22,895,319.00	23,047,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,985,992.00	2,720,000.00
210304	Байрны түрээс		500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,397,765.18	18,518,300.00
210401	Бичиг хэрэг	3,227,500.00	4,380,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,932,100.00	6,651,500.00

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,705,976.18	4,956,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,532,189.00	2,530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,409,200.00	6,429,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,980,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	429,200.00	4,429,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,649,200.00	5,825,560.00
210702	Дотоод албан томилолт	3,649,200.00	5,825,560.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,552,820.33	27,001,293.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,290,541.00	19,335,223.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	1,428,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	399,825.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	41,250.00	50,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,926,160.00	5,117,170.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,789,044.33	550,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	9,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400,000.00	9,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,628,755,800.37	43,766,969,388.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,850,791,295.64	40,403,887,473.75
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,806,336,292.90	40,342,401,314.75
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,692,500.00	9,120,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,374,802.74	9,687,659.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		42,678,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,387,700.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,777,964,504.73	3,363,081,914.59
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,777,964,504.73	3,363,081,914.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	648,132,478.48	656,706,733.02

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	648,132,478.48	656,706,733.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	421,336,087.73	1,069,468,566.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,069,468,566.21	1,726,175,299.23

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Б у с а д	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,709,914.75	273,845,547.26	675,546,999.98		1,124,102,461.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			206,673,119.40		206,673,119.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,709,914.75	273,845,547.26	882,220,119.38		1,330,775,581.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		271,139,366.59			-271,139,366.59
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	6,970,000.00				6,970,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			538,591,749.92		538,591,749.92
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	1,420,811,869.30		1,605,197,964.72
D01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	1,420,811,869.30		1,605,197,964.72

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			31,886,328.26		31,886,328.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	1,452,698,197.56		1,637,084,292.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.0		0.01
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			681,362,185.52		681,362,185.52
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,679,914.75	2,706,180.67	2,134,060,383.09		2,318,446,478.51

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,334,487,600.00	40,941,689,461.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,334,487,600.00	40,941,689,461.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,484,500.00	548,609,646.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,108,500.00	411,467,431.00
210101	Үндсэн цалин		

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		338,952,000.00	337,702,682.00
210102	Нэмэгдэл	65,828,500.00	65,320,749.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,328,000.00	8,444,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,742,900.00	48,132,922.54
210201	Тэтгэврийн даатгал	33,145,200.00	32,220,178.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,899,500.00	3,980,592.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,119,500.00	3,181,586.18
210204	Ажилгүйдлийн даатгал	779,900.00	794,193.22
210205	Эрүүл мэндийн даатгал	7,798,800.00	7,956,372.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,525,800.00	29,525,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,258,000.00	3,258,000.00
210302	Түлш, халаалт	23,047,800.00	23,047,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,720,000.00	2,720,000.00
210304	Байрны түрээс	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,518,300.00	18,518,300.00
210401	Бичиг хэрэг	4,380,000.00	4,380,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,651,500.00	6,651,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,956,800.00	4,956,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,530,000.00	2,530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,429,200.00	6,429,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,429,200.00	4,429,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,985,600.00	4,985,600.00
210702	Дотоод албан томилолт	4,985,600.00	4,985,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,374,200.00	26,450,393.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,344,900.00	19,335,223.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл		

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ТОГТООХ	1,428,000.00	1,428,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,031,300.00	5,117,170.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	3,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,100,000.00	3,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,779,003,100.00	40,393,079,814.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,779,003,100.00	40,393,079,814.75
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	40,728,324,600.00	40,342,401,314.75
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,000,000.00	8,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,678,500.00	42,678,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,334,487,600.00	13,179,675,824.86
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,158,548,092.25	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	30,158,548,092.25	
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,175,939,507.75	13,148,780,180.48
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	11,175,939,507.75	13,148,780,180.48
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	30,895,644.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,049,219.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		846,424.87
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,069,468,566.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,726,175,299.23
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1.00
610001	Төсвийн байгууллага		1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	39.00
620001	Удирдах ажилтан		

Булган аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

			1.00
620002	Гүйцэтгэх ажилтан		33.00
620003	Үйлчлэх ажилтан		5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39.00	39.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	28.00	28.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00